





НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 08 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2025 оны 09 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлэ эгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
1	<p>Үүрэг, даалгавар НЭГ: Дүүргийн хэмжээнд борооны усны хаялгын чиглэлээр өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй үзлэг шалгалтыг зохион байгуулах.</p> <p>Дүүргийн Онцгой байдлын хэлтэс, хороодын Засаг дарга нартай хамтран үерийн далан сувгийн үзлэг шалгалтыг зохион байгуулж дүүргийн 13 дугаар хороо, Хайлаастын далан дахь бетон хийцлэлийн хогийг нийслэлийн Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ-т мэдэгдэж ачиж тээвэрлүүлэн далан сувгийн аюулгүй байдлыг хангуулан ажилласан.</p> 	-	Хэрэгжилтийг ханган ажиллана.	70
2	<p>Үүрэг, даалгавар ХОЁР: Явган замын засвар, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусгах, ажлаа хийхгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гэрээг цуцлах.</p> <p>Дүүргийн 6 дугаар хороо, Их тойруугийн гудамжны хойд хэсэг, Баянбүрдийн тойргоос Гэсэр сүм хүртэлх 4000м2 явган хүний замын ажлыг "Төрөлхмөрөн" ХХК, 4 дүгээр хороо, Бага тойруугийн гудамжны хойд хэсэг, Анкарагийн гудамжинд 9000м2 явган хүний замын ажлыг "Сантбаян бэрх" ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд тус бүрд нь ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлж стандартыг баримтлан чанартай хийж гүйцэтгэх талаар чиглэл хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.</p> 	-	Хэрэгжилтийг ханган ажиллана.	70

	<p>Үүрэг, даалгавар ГУРАВ: Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, гэр болон байшингийн дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох ажлуудаа иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах ажлыг эхлүүлэх.</p>		
3	<p>Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран “Яндангаа авч, өрхөө бүтээх нь угаартах эрсдэлтэй”, “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх таван алхам” пост, анхааруулга, сэрэмжлүүлгийг дүүргийн социал хаягууд, хороодын цахим хаягуудаар түгээж ажилласан. Дулаалгын аяны хүрээнд гэр сууцны дулаалгын багцын талаарх мэдээллийг өдөр тутмын “Монголын үнэн”, “Өнөөдөр” сонинд гаргуулсан. Мөн “Тэнгэр” телевизээр “Хагас коксон түлш гэж юу вэ” цуврал дугаар бүхий контентийг оруулж, дүүргийн 7-24 дүгээр хороодын цахим хуудсаар түгээлгэж, иргэд олон нийтэд мэдээллийг сурталчлан ажиллаж байна.</p> <p>Амины орон сууцны дулаалгын танилцуулга, загвар рүүм-ийг дүүргийн 14 дүгээр хороонд байрлуулсан ажиллаж, иргэд олон нийтэд тогтмол танилцуулж байна. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй гэр сууцны загвар гэрийг мөн 14 дүгээр хорооны иргэний танхимын дэргэд барьж, иргэдэд гэрийн дулаалгын мэдээллийг бодитоор үзүүлж танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	Хэрэгжилтийг ханган ажиллана.	70
	<p>Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Шинээр худалдан авсан хот, нийтийн аж ахуйн машин, техник, тоног, төхөөрөмжийг ажилд нь гаргах.</p>		
4	<p>Дүүргийн нийтийн аж ахуйн цэвэрлэгээ, үйлчилгээнд ашиглахаар DULEVO 850, DONGFENG загварын зам талбай шүүрдэгч машинуудыг худалдан авсан бөгөөд дүүргийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг бүрэн хариуцан ажиллаж байна.</p>  		100
	<p>Үүрэг, даалгавар ТАВ: Сургууль, цэцэрлэгийн бэлэн байдлыг хангаж, засвар, шинэчлэлийн ажлыг хийж дуусгах, багшлах боловсон хүчний хангалтыг хэвийн болгоход анхаарч ажиллах.</p>		
5	<p>Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын их болон урсгал засварын явцын судалгааг авч, хүргүүлсэн. Дүүргийн 140 дүгээр сургууль, 222 дугаар цэцэрлэгийн цогцолборын шугам сүлжээний засварын ажил дуусаагүй байсан тул 2025 оны 09 дүгээр сарын 01-нд хичээл сургалтын үйл ажиллагаа эхлээгүй, 09 дүгээр сарын 02-ны өдрөөс хэвийн үргэлжилсэн.</p>	Хэрэгжилтийг ханган ажиллана.	50

	<p>2025 оны 08 дугаар сарын байдлаар боловсролын байгууллагын хүний нөөцийн сул орон тооны мэдээлэл: Ерөнхий боловсролын сургуульд 129 багш, 75 үйлчилгээний албан хаагч, нийт 204, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 80 багш, 96 үйлчилгээний албан хаагч, нийт 176 хүн дутагдалтай байсан.</p> <p>Сул орон тооны мэдээллийг нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар Ерөнхий боловсролын сургуульд 67 багш, 34 үйлчилгээний албан хаагч, үүнээс англи хэлний 11, математикийн 13 багш дутагдалтай байна, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 24 багш, 63 үйлчилгээний албан хаагч дутагдалтай байгаагаас сэтгэл зүйч 16, хоол зүйч 17, хөгжмийн багш 11 тус тус дутагдалтай байна.</p>			
	<p>Үүрэг, даалгавар ЗУРГАА: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, хүнсний, бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, стандартыг мөрдүүлж, аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтыг хийх.</p> <p>2025-2026 оны хичээлийн жилд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангид үдийн хоол өгдөг 18 сургууль байгаагаас гал тогоогоо бие даан ажиллуулж буй 13 сургууль (5, 17, 23, 24, 49, 57, 61, 72, 138, 139, 140, 145, 149), түрээсийн гэрээг үргэлжлүүлж байгаа 5 сургууль (37, 39, 50, 112, 117) байна.</p> <p>2025 оны 09 дүгээр сарын 01-нд 17, 39, 49, 57 дугаар сургуулийн гал тогоонд хяналт тавьж ажилласан бөгөөд 17, 49, 57 дугаар сургуулиуд гал тогоогоо бие даан ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж хүүхдүүдэд халуун хоол, сүү сүүн бүтээгдэхүүн өгч байна. 2025 оны 09 дүгээр сард багтаан ажлын хэсэг батлагдсан хуваарийн дагуу сургууль, цэцэрлэгийн гал тогоонд хяналт тавин ажиллахаар бэлтгэл ажлыг хангаад байна.</p>		Хэрэгжилтийг ханган ажиллана.	30
	<p>Үүрэг, даалгавар ДОЛОО: Дүүргүүд борооны улмаас эвдэрч гэмтсэн автозам, гудамж, талбай, ногоон байгууламжуудаа нөхөн сэргээх ажлуудаа эрчимжүүлэх.</p>			
7	<p>Дүүргийн Ерөнхий боловсролын 39 дүгээр сургуулийн урд талын авто зам дагуух ургамлан хашлага их хэмжээгээр орсон борооны улмаас үерт өртөж ургах боломжгүй болсон тул намрын тарилтаар нөхөн тарих талаар гүйцэтгэгч байгууллагад мэдэгдсэн. Мөн дүүргийн 12 дугаар хороо, Булгийн 16 дугаар гудамж орчим (Дэнжийн мянгын авто зам дагуу)-д явган хүний замын зорчих хэсэг үерийн усанд эвдэрч урсаж алга болсон (байнга ус тогтдог байршил) тул уг байршилд ус зайлуулах шугамын ажлыг Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлсэн.</p>		Хэрэгжилтийг ханган ажиллана.	70

					
--	---	--	--	--	--

47°56'55.658777" N 106°53'49.907833" E
735 Deyi, 1000 Street
Shibei, Datan
Chinghai, Datan
Ulaanbaatar

Үүрэг, даалгавар НАЙМ: Үерийн аманд байгаа айл, өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.

8	<p>Дүүргийн Засаг даргын 2025 оны "Гол, усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" А/243 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Газар зохион байгуулалтын алба хамтран 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдөр дүүргийн 24 дүгээр хорооны үерийн эрсдэлтэй бүсэд суурьшсан эрсдэлд өртөх магадлалтай 100 айл өрхөд нүүлгэн шилжүүлэх мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд одоогоор нүүлгэн шилжүүлэх ажил хийгдээгүй байна.</p> <p>Мөн дүүргийн Газар зохион байгуулалтын албанд 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр 27.10/466 дугаар албан бичиг хүргүүлж дүүргийн эрсдэлтэй бүсэд байгаа нэгж талбар, байршлын мэдээллийг авсан бөгөөд 24 дүгээр хороонд үерийн эрсдэлтэй бүсэд суурьшсан зөвшөөрөлтэй 162, зөвшөөрөлгүй 24, нийт 186 өрх байна.</p>	-	Хэрэгжилтийг ханган ажиллана.	50
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ				63.7%

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА


ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТЭСИЙН ДАРГА

Н.МАНДУУЛ

Ж.ТАМИР

М.НАВЧАА

НЭГТГЭЖ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Э.БУЯН-ӨЛЗИЙ